



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/24

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, “2023 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг үндэслэн Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн 1 дүгээр багц Төрийн үйлчилгээний ТҮЦ буюу Киоск машин худалдан авах ажлыг “Нью компас” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Нью компас” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 24,000,000 (хорин дөрвөн сая) төгрөгийг гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч гэрээний дагуу санхүүжилт өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

622301175

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/